



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 11 сарын 11 өдөр

Дугаар А/451.

Улаанбаатар хот

「Сүхбаатар дүүргийн 51 дүгээр цэцэрлэгийн
эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 11 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Сүхбаатар дүүргийн 51 дүгээр цэцэрлэгийн эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 6,501,769.20 (зургаан сая таван зуун нэг мянга долоон зуун жаран есөн төгрөг хорин мөнгө) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Сүхбаатар дүүргийн 51 дүгээр цэцэрлэг (Д.Сарантуяа)-т зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй 5 нэр төрлийн 1,597,069.20 (нэг сая таван зуун ерэн долоо мянга жаран есөн төгрөг хорин мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтад зохих журмын дагуу устгалын акт үйлдэн устгах, 3 нэр төрлийн 4,904,700.00 (дөрвөн сая есөн зуун дөрвөн мянга долоон зуу) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий татан төвлөрүүлэхээр шийдвэрлэсэн хөрөнгийг Нийслэлийн Өмчийн харилцааны газарт актаар хүлээлгэн өгөхийг Сүхбаатар дүүргийн 51 дүгээр цэцэрлэг (Д.Сарантуяа)-т, татан төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж, ажиллахыг Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс (Т.Оюунтуул)-т тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА

1150501/20

ийн Өмчийн харилцааны газрыг
2024 оны 11... дугаар сарын 11...-д
ДНБ... дугаар тушаалын хавср...

СБД-ийн 51 дүгээр цэцэрлэгийн эзэмшилд байгаа эд хөрөнгийн
ДАНСНААС ХАСАХ ТУХАЙ САНАЛ

[illegible]